| | | | | |
|---|---|---|---|---|
| 15 | Орчны бүсийн зээлийн эргэлтийн сангийн үйл ажиллагааны зөвлөх үйлчилгээ | Зөвлөх үйлчилгээ | Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/314 дүгээр тушаалаар үнэлгээний хороо тушаалаар байгуулагдсан. Тус тендерийн төсөвт өртөг нь төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 200,000.0 еврогоор батлагдсаныг үндэслэн тус тендер шалгаруулалтыг ХБНГУ-ын Сэргээн босголт, Зээлийн банк *(KfW)*-ны *"Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх үйлчилгээ, Ажил, Үйлдвэр, Барааны болон Зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны удирдамж"*-ын 2.1.2 *"Үндэсний нээлттэй тендер шалгаруулалт журам"*-ын дагуу зохион байгууллаа. Тус тендерийн Зөвлөмж, Үнэлгээний тайланг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлэн танилцууллаа. Тендер хүлээн авах эцсийн хугацаан дотор ирсэн тендерүүд нь тендерийн баримт бичигт заасан шаардлагад нийцээгүй мөн техникийн саналууд нь үндсэн шаардлага (авбал зохих доод оноог авах)-ыг хангаагүй тул ХБНГУ-ын Сэргээн босголтын Зээлийн банк (*KfW*)-ны "Түншлэгч улсуудтай хийх санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд рөгийн үнийн дүн бүхий дугаартай №ЗСШ-02/122, 22/48 гэрээг байгуулсан. улалтад МУ-ын Засгийн газраас зарцуулах ашиглалтын болон урсгал зардал зардлын тооцоог нэгтгэн 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдөр Төслийн зөвлөх багт мэдээллийг хүргүүлсэн болно. Монгол Улсын Засгийн газраас тус хөрөнгө оруулалтад зарцуулах зардал: 159,765,732.0 төгрөг (ойролцоогоор 48,805.34 евро) . "Хамгийн сайн" тендер ирүүлсэн оролцогч "Мөнх ногоон тал" ХХК-д гэрээ байгуулах эрх олгох тухай 2022 оны 08 дугаар сарын 2 | 50 |
| 16 | Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих багийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээ | Зөвлөх үйлчилгээ | Тендер шалгаруулалт явагдаж дууссан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 20-ны өдөр баталсан А/280 тоот гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах тухай тушаалын дагуу "Некст степ инженеринг" ХХК-тай 330,000,000 төгрөгийн үнэ бүхий 2022 оны 08 дугаар сарын 01-ний өдөр байгуулсан. Гэрээт ажлыг 2022 оны 08 дугаар сарын 01 – 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэнэ | 100 |
| 17 | Байгаль хамгаалагчийн байр болон хөдөлгөөнт хяналтын постны барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ | Зөвлөх үйлчилгээ | Төслийн барилгын зөвлөх баг "Некст степ инженеринг" ХХК-аас Ажлын даалгавар ирүүлээгүй байна. | - |
| 18 | Баруун бүсийн ССМТ-ийн хэрэгцээт байдлын судалгаа | Зөвлөх үйлчилгээ | Төслийн хүрээнд баригдах барилгуудын зураг төсөл, ажлын гүйцэтгэл, чанарт инженерийн хяналт тавих багийг сонгон шалгаруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан "Некст степ инженеринг" ХХК ажлын даалгаврыг шинэчлэн, хөндлөнгийн шинжээч Др. Намхай тус ажлыг хийж гүйцэтгэснийг төслийн удирдах хороонд танилцуулсан. | 100 |
| 19 | Баруун бүсийн ССМТ-ийн барилгын хөрсний геологи, геодезийн шинжилгээ хийж дүгнэлт гаргах, барилгын ажлын зураг, төсөв боловсруулах, зохиогчийн хяналт тавих зөвлөх үйлчилгээ | Зөвлөх үйлчилгээ | Байгаль хамгаалагчийн байр болон хөдөлгөөнт хяналтын постын барилгын ажлын зураг, төсөв боловсруулах талаар уулзалтыг 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр БОАЖЯ-ны ТХБНУГ-ын төлөөллийг байлцуулан зохион байгуулсны дагуу захиалагч талаас 2022 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн 09/4585 дугаартай албан бичгээр ажлын даалгаварт тавих шаардлагыг хүлээн авсан. Төслийн хүрээнд 2017 онд Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн байгаль хамгаалагчийн байрны зураг төслийг боловсруулсан "Бадмаараг төсөл" ХХК нь тус зураг төслийг шинэчлэн боловсруулахаас татгалзсан учир шинээр гүйцэтгэгч сонгон шалгаруулах, төсөвт өртгийг нэмэгдүүлэх шаардлага гарсан. Тус ажил Баруун бүсийн СМТ болон бусад барилгын зургийн ажилтай хамт хийхээр төслийн 2023 оны төлөвлөгөөнд тусгагдсан. | 30 |
| 20 | Хог хаягдал тээвэрлэх, цуглуулах, булшлах менежментийн зураглал хийх зөвлөх үйлчилгээ | Зөвлөх үйлчилгээ | Тендер шалгаруулалт явагдаж дууссан. БОАЖЯ-ын ТНБД-ын 2022 оны 04 дүгээр сарын 13-ний өдрийн А/122 дугаар тушаалаар 69,826,000 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-19/22, 22.110 дугаартай гэрээг "Байгаль орчин, эрүүл мэндийн төв" холбоо /НҮББ/ -тай 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан. | 100 |
| 21 | Сонгогдсон ТХГН-ийн менежментийн үр ашигт байдлын суурь судалгааны зөвлөх үйлчилгээ | Зөвлөх үйлчилгээ | Тендер шалгаруулалт явагдаж дууссан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/410 дугаартай тушаалаар 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр "Байгаль хамгааллын судалгаа хөгжлийн төв" НҮТББ-тай 62,736,300 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-21/22, 21/262 дугаартай гэрээг байгуулсан. | 100 |
| 22 | Сонгогдсон ТХГН-ийн биологийн олон янз байдлын судалгаа хийх | Зөвлөх үйлчилгээ | Тендер шалгаруулалт явагдаж дууссан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн А/297 дугаартай гэрээ байгуулах, хөрөнгө зарцуулах тушаалаар Монгол Улсын Их Сургуулийн Шинжлэх ухааны сургуультай 65,880,000 төгрөгийн үнийн дүн бүхий гэрээг байгуулсан | 100 |
| 23 | ЮНЕСКО-ийн Хүн ба шим мандлын хөтөлбөрт зарим ТХГН-ийг бүртгүүлэхэд шаардлагатай дэмжлэг үзүүлэх зөвлөх үйлчилгээ | Зөвлөх үйлчилгээ | Тус тендерийн үнэлгээний хороо Төрийн нарийн бичгийн даргын А/387 дугаар тушаалаар 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр байгуулагдлаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газрын захиалгаар төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан болно.<br>Захиалагчаар батлагдсан ажлын даалгаврыг үнэлгээний хороонд Тусгай хамгаалалттай бүс нутгийн удирдлагын газраас ирүүлээгүй болно. Захиалагчаас үнэлгээний хороонд ирүүлэх батлагдсан ажлын даалгаврыг хүлээж байна. | - |
| 24 | ТХГН-ийн газар ашиглалтын үйл ажиллагаа цахимжуулах, хөгжүүлэлт хийх | Зөвлөх үйлчилгээ | Тендер шалгаруулалт явагдаж дууссан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн А/424 дугаартай тушаалаар 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр "Софт мастер" ХХК-тай 59,400,000 төгрөгийн үнийн дүн бүхий ЗСШ-24/22, 22/273 дугаартай гэрээг байгуулсан. | 100 |
| 25 | Биологийн олон янз байдлын мэдээллийн санг шинэчлэх, зураглал хийх №ЗСШ-27/22 | Зөвлөх үйлчилгээ | Тендерийн үнэлгээний хороо 2022 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн Төрийн нарийн бичгийн даргын А/37 дугаар тушаалаар байгуулагдсан. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд Төрийн нарийн бичгийн даргын А/160, А/189 дугаар тушаалаар өөрчлөлт орсон болно. Тус тендерийн төсөвт өртөг нь 2022 оны 06 дугаар сарын 17-ний өдрийн Төслийн худалдан авах ажиллагааны шинэчилсэн төлөвлөгөөгөөр 18,000 евро болж батлагдсаныг үндэслэн тус тендер шалгаруулалтыг Сэргээн босголт, Зээлийн банк (KfW)-ны "Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх үйлчилгээ, Ажил, Үйлдвэр, Барааны болон Зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам"-ын 2.1.5 "Гэрээ шууд байгуулах журам" заалтын дагуу зохион байгууллаа. Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд Сэргээн босголт, Зээлийн банк (KfW)-ны "Түншлэгч улсуудтай хийх Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Зөвлөх үйлчилгээ, Ажил, Үйлдвэр, Барааны болон Зөвлөхийн бус үйлчилгээ худалдан авах ажиллагааны журам"-ын 2.5.13 заалтыг үндэслэн гэрээ байгуулах эрх олгох тухай 2022 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 03/3597 тоот албан бичгээр мэдэгдсэн болно. 06 дугаар сарын 28-ны өдөр гэрээ байгуулахын өмнөх уулзалтыг зохион байгуулсан бөгөөд хурлын тэмдэглэлийг хуралд оролцогч талуудаар баталгаажуулан гэрээний барим бичгийн Нэмэлт хавсралт (57 дугаар хуудас)-аар оруулсан болно. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн даргын Гэрээ байгуулах эрх олгох, хөрөнгө зарцуулах тухай А/244 дүгээр тушаал 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдөр батлагдлаа. Байгаль орчны мэдээллийн сан дах биологийн олон янз байдлын хамгаалал, байгаль орчны нөлөөлөл, амьтан, ургамалтай холбоотой мэдээллийн дэд сангуудыг уялдуулан холбож Биологийн олон янз байдлын мэдээллийн санг шинэчлэн хөгжүүлэх, хуучин байгаа мэдээллийн сангуудын агуулга бүтцийг сайжруулж, программ хангамжид нэмэлт өөрчлөлт оруулан сайжруулж, мэдээ, мэдээллээр баяжуулах 59,400,000.0 (Тавин есөн сая дөрвөн зуун мянган) төгрөгийн 6 сарын хугацаатай гэрээг Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнтэй 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдөр байгууллаа. | 100 |
| 26 | Уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг өндөр уулсын ургамлын нэн ховор, ховор, мэдрэг түлхүүр зүйлийн суурь судалгаа | Зөвлөх үйлчилгээ | Тендер шалгаруулалт явагдаж дууссан. БОАЖЯ-ны ТНБД-ын 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн А/311 дугаартай тушаалаар 2022 оны 08 дугаар сарын 09-ний өдөр Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Математик, Байгалийн Ухааны сургуультай 64,500,000 төгрөгийн үнийн дүн бүхий ГШБ-10/22, 22/180 дугаартай гэрээг байгуулсан. | 100 |
| 27 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахад дэмжлэг үзүүлэх | Зөвлөх үйлчилгээ | Тендерийн үнэлгээний хороо Төрийн нарийн бичгийн даргын А/449 дүгээр тушаалаар 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдөр байгуулагдлаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсийн захиалгаар төслийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан болно.<br>Захиалагчаар батлагдсан ажлын даалгаврыг үнэлгээний хороонд Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтсээс ирүүлээгүй болно. Захиалагчаас үнэлгээний хороонд ирүүлэх батлагдсан ажлын даалгаврыг хүлээж байна. | - |

